

Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 362 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх” журмын 3.1.10 дахь заалт

ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНЦЛОГ БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ ОЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

1.Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог барааны тодорхойлолт хүссэн хүсэлт (нэр, хаяг, регистр, утасны дугаар, хилээр нэвтрүүлж буй зорилго, хугацаа, хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн төрөл, боомтын нэр, хилээр нэвтрүүлэх он, сар, өдөр, хүлээн авагчийн хаяг)

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

3. Гаалийн хилээр нэвтрүүлэх үндэслэл болох баримт, түүний дугаар /гэрээ, протокол, г.м./

4. Зохистой дадал, удирдлагын хяналтын тогтолцоог нэвтрүүлсэн тухай бичиг баримтын хуулбар

/Хүнсний тухай хуулийн 11.2.2-т “импортлох хүнс нь зохистой дадал, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх”, Засгийн газрын 2013 оны 191 дүгээр тогтоолоор баталсан Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журмын 3.2.3-т “Экспортлогч, импортлогч улсын эрх бүхий байгууллагаас үйлдвэрлэгчид олгосон зохистой дадал, удирдлагын хяналтын тогтолцоо (GAP, GHP, GMP, ISO, HACCP гм)-г нэвтрүүлсэн тухай бичиг баримтын хуулбар”, 3.2.4-т “Экспортлогч улсын эрх бүхий байгууллага болон үйлдвэрлэгчээс бүтээгдэхүүн (гарал үүсэл, ургамлын эрүүл ахуй, чанар болон эрүүл мэндийн гэрчилгээ)-д олгосон баталгаажуулалтын бичиг баримт” г.м./

5.Бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, үнэ

№	Барааны код	Барааны нэр /Этилийн спиртийн ангилал, агууламж, %, эзэлхүүн, л/	Тоо хэмжээ, л эсвэл ш	Үнэ